

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/100/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023.02.17	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Албан шаардлага	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

№ 2023.02.15 № 2/22

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,314,310.9 мянган төгрөг болж өмнөх оноос 1,962,185.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд ТӨБЗГ-ын 2022.05.13-ны өдрийн 198 дугаар тогтоолоор 2,043,583.2 мянган төгрөгийн өртөг бүхий конторын барилгыг үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг

D- alban bichig 2022 A4 TOOT

005020165

хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 A4 TOOT

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,773,116.14	73,975,225.92
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0	3,540,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0	3,540,000.00
31210	Төгрөг	0	3,540,000.00
31211	Төрийн сангийн харилцах	0	3,540,000.00
33	АВЛАГА	100,872.00	0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	100,872.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	83,672,244.14	70,435,225.92
35400	Хангамжийн материал	83,672,244.14	70,435,225.92
35410	Бичиг хэргийн материал	6,001,951.00	4,725,071.00
35420	Аж ахуйн материал	25,805,507.46	15,301,507.46
35440	Түлш, шатах тослох материал	1,255.08	408.08
35450	Барилгын засварын материал	380,000.00	0
35470	Бусад хангамжийн материал	51,483,530.60	50,408,239.38
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	394,388,301.07	2,314,310,916.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	394,388,301.07	2,314,310,916.69
39200	Биет хөрөнгө	351,013,301.07	2,269,310,916.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	103,822,850.00	2,043,583,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,949,550.80	-19,955,592.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	108,990,000.00	108,990,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-63,627,124.93	-81,775,552.73
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	264,027,674.32	292,355,950.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	-72,741,757.98	-111,053,887.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,817,135.00	59,289,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,325,924.54	-22,122,201.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,780,000.00	3,780,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,780,000.00	-3,780,000.00
39300	Биет бус хөрөнгө	43,375,000.00	45,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	43,375,000.00	45,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	478,161,417.21	2,388,286,142.61
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	478,161,417.21	2,388,286,142.61
51	Засгийн газрын хувь оролцоо	478,161,417.21	2,388,286,142.61
51100	Засгийн газрын оруулсан капитал	268,961,050.75	0
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	268,961,050.75	0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	268,961,050.75
51200	Хуримтлагдсан үр дүн	73,749,629.89	1,983,874,355.29
51210	Өмнөх үеийн үр дүн	134,815,790.05	73,749,629.89
51220	Тайлант үеийн үр дүн	-61,066,160.16	1,910,124,725.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	135,450,736.57	135,450,736.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	478,161,417.21	2,388,286,142.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,046,513,178.18	3,124,040,605.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,644,546.18	2,123,386,105.94
120	Нийтлэг татварын бус орлого	41,644,546.18	2,123,386,105.94
120009	Бусад орлого	3,699,500.00	7,513,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,993,146.18	2,104,724,076.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,951,900.00	11,148,729.38
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,004,868,632.00	1,000,654,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	996,868,632.00	987,154,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	996,868,632.00	987,154,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,000,000.00	13,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	1,500,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,107,579,338.34	1,136,966,078.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,107,579,338.34	1,136,966,078.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,049,610,618.74	1,118,762,641.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	665,942,438.40	701,839,476.00
210101	Үндсэн цалин	374,446,255.00	418,238,180.00
210102	Нэмэгдэл	142,361,111.60	117,137,918.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,957,804.08	64,169,000.00
210104	Урамшуулал	94,177,267.72	102,294,378.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,309,715.00	86,038,883.00
210201	Тэтгэврийн даатгал	60,566,803.86	62,523,004.72
210202	Тэтгэмжийн даатгал	6,662,900.00	3,446,107.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,330,300.00	6,017,657.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,332,600.00	1,195,372.73
210205	Эрүүл мэндийн даатгал	12,417,111.14	12,856,740.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,079,007.00	85,033,211.00
210301	Гэрэл, цахилгаан	5,167,375.00	5,640,349.00
210302	Түлш, халаалт	63,696,864.00	72,796,416.00
210303	Цэвэр, бохир ус	17,214,768.00	6,596,446.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,449,680.00	19,765,944.91
210401	Бичиг хэрэг	18,936,810.00	5,457,450.91
210402	Тээвэр, шатахуун	5,578,270.00	4,977,147.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,142,670.00	3,955,737.00
210404	Ном, хэвлэл	246,800.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	570,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,975,130.00	4,775,610.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,187,000.00	1,365,629.09
210601	Багаж, техник, хэрэгсэл	562,000.00	0
210604	Урсгал засвар	1,625,000.00	1,365,629.09
2107	Томилолт, зочны зардал	4,890,000.00	1,579,000.00
210702	Дотоод албан томилолт	4,890,000.00	1,579,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,236,350.00	85,431,278.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,666,889.00	84,573,134.00
210803	Даатгалын үйлчилгээ	178,200.00	178,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,952.00	242,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	938,809.00	0
210807	Газрын төлбөр	173,500.00	393,500.00

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,516,428.34	137,709,219.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,526,100.00	27,158,320.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	2,699,240.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,990,328.34	107,851,659.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,968,719.60	18,203,437.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,492,412.00	0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,992,412.00	0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,476,307.60	18,203,437.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,476,307.60	18,203,437.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-61,066,160.16	1,987,074,527.33
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	76,949,801.93
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	76,949,801.93
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-61,066,160.16	1,910,124,725.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,008,568,132.00	1,008,167,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,699,500.00	7,513,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,699,500.00	7,513,300.00
120009	Бусад орлого	3,699,500.00	7,513,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,004,868,632.00	1,000,654,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	996,868,632.00	987,154,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	996,868,632.00	987,154,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,000,000.00	13,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	1,500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,008,568,132.00	1,004,627,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,008,568,132.00	1,004,627,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	950,599,412.40	986,424,363.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	666,023,727.40	695,798,737.14
210101	Үндсэн цалин	374,443,255.00	414,917,812.14
210102	Нэмэгдэл	142,361,111.72	111,948,017.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	54,957,804.88	64,436,000.00
210104	Урамшуулал	94,261,555.80	104,496,908.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,309,715.00	84,893,749.86
210201	Тэтгэврийн даатгал	60,566,803.86	60,108,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,662,900.00	7,071,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,330,300.00	5,657,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,332,600.00	1,414,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,417,111.14	10,641,849.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,079,007.00	85,033,211.00
210301	Гэрэл, цахилгаан	5,167,375.00	5,640,349.00
210302	Түлш, халаалт	72,796,416.00	72,796,416.00
210303	Цэвэр, бохир ус	8,115,216.00	6,596,446.00

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
2104	Хангамж, бараа материалын зардал	25,225,669.00	18,108,147.00
210401	Бичиг хэрэг	6,535,940.00	4,102,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,672,000.00	4,886,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,507,929.00	3,955,737.00
210404	Ном, хэвлэл	285,800.00	0
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	570,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,654,000.00	4,564,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,942,000.00	1,794,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	995,000.00	0
210604	Урсгал засвар	2,947,000.00	1,794,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,890,000.00	1,579,000.00
210702	Дотоод албан томилолт	4,890,000.00	1,579,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,353,414.00	95,516,278.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,723,712.00	94,658,134.00
210803	Даатгалын үйлчилгээ	178,200.00	178,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,952.00	242,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,999,050.00	0
210807	Газрын төлбөр	173,500.00	393,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,775,880.00	3,701,240.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	502,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,775,880.00	3,199,240.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,968,719.60	18,203,437.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,492,412.00	0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,992,412.00	0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,476,307.60	18,203,437.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,476,307.60	18,202,137.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	1,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	3,540,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	3,540,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	3,540,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	134,815,790.05	539,227,577.37
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	134,815,790.05	539,227,577.37
3	Тайлант үеийн үр дүн	0	0	-61,066,160.16	-61,066,160.16
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	73,749,629.89	478,161,417.21
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	73,749,629.89	478,161,417.21
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	73,749,629.89	478,161,417.21
7	Тайлант үеийн үр дүн	0	0	1,910,124,725.40	1,910,124,725.40
8	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	268,961,050.75	135,450,736.57	1,983,874,355.29	2,388,286,142.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	987,154,500.00	968,952,363.00	18,202,137.00	98.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	987,154,500.00	968,952,363.00	18,202,137.00	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ	987,154,500.00	968,952,363.00	18,202,137.00	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	707,160,300.00	695,798,737.14	11,361,562.86	98.4
210101	Үндсэн цалин	421,512,400.00	414,917,812.14	6,594,587.86	98.4
210102	Нэмэгдэл	126,394,000.00	111,948,017.00	14,445,983.00	88.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	65,340,000.00	64,436,000.00	904,000.00	98.6
210104	Урамшуулал	93,913,900.00	104,496,908.00	-10,583,008.00	111.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,395,100.00	84,893,749.86	3,501,350.14	96.0
210201	Тэтгэврийн даатгал	60,108,700.00	60,108,700.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,071,600.00	7,071,600.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,657,200.00	5,657,200.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,414,400.00	1,414,400.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,143,200.00	10,641,849.86	3,501,350.14	75.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	87,099,400.00	85,033,211.00	2,066,189.00	97.6
210301	Гэрэл, цахилгаан	7,594,800.00	5,640,349.00	1,954,451.00	74.3
210302	Түлш, халаалт	72,796,500.00	72,796,416.00	84.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	6,708,100.00	6,596,446.00	111,654.00	98.3
2104	Хангамж, бараа материалын зардал	18,696,900.00	18,094,847.00	602,053.00	96.8
210401	Бичиг хэрэг	4,155,900.00	4,088,700.00	67,200.00	98.4
210402	Тээвэр, шатахуун	4,896,900.00	4,886,300.00	10,600.00	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,636,400.00	3,955,737.00	-319,337.00	108.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	599,700.00	600,000.00	-300.00	100.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,408,000.00	4,564,110.00	843,890.00	84.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,802,700.00	1,794,000.00	8,700.00	99.5
210604	Урсгал засвар	1,802,700.00	1,794,000.00	8,700.00	99.5
2107	Томилолт, зочны зардал	1,878,200.00	1,579,000.00	299,200.00	84.1
210702	Дотоод албан томилолт	1,878,200.00	1,579,000.00	299,200.00	84.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,152,400.00	78,057,578.00	94,822.00	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	77,294,200.00	77,199,434.00	94,766.00	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	178,200.00	178,200.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	242,500.00	242,444.00	56.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	393,500.00	393,500.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,969,500.00	3,701,240.00	268,260.00	93.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	502,000.00	502,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,467,500.00	3,199,240.00	268,260.00	92.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	987,154,500.00	987,154,500.00	0.00	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	987,154,500.00	987,154,500.00	0.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	987,154,500.00	987,154,500.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,000,000.00	13,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,000,000.00	13,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,000,000.00	13,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,000,000.00	13,500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00	13,500,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,000,000.00	13,500,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,000,000.00	13,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	12,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	1,500,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Татварын хэлтэс нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ.

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих.
- Улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх
- Төрийн захиргааны удирдлагаар хангах, хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх
- Мэдээллийн технологид суурилсан “Цахим татварын алба” болох.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ний А/156 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,910,124.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,773.1	17.5%	73,975.2	3.1%	(9,797.9)	-11.7%
Мөнгөн хөрөнгө	-	0.0%	3,540.0	0.1%	3,540.0	0.0%
Авлага	100.9	0.0%	-	0.0%	(100.9)	-100.0%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	83,672.2	17.5%	70,435.2	2.9%	(13,237.0)	-15.8%
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	394,388.3	82.5%	2,314,310.9	96.9%	1,919,922.6	486.8%
Үндсэн хөрөнгө	590,812.7	123.6%	2,552,998.2	106.9%	1,962,185.5	332.1%
Хуримтлагдсан элэгдэл	(196,424.4)	-41.1%	(238,687.2)	-10.0%	(42,262.9)	21.5%
Нийт хөрөнгө	478,161.4	100.0%	2,388,286.1	100.0%	1,910,124.7	399.5%
Өр төлбөр	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	478,161.4	100.0%	2,388,286.1	100.0%	1,910,124.7	399.5%
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	478,161.4	100.0%	2,388,286.1	100.0%	1,910,124.7	399.5%

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь тайлант ахмадын сангийн дансны үлдэгдэл 3,540.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 70,435.2 мянган төгрөг болж 13,237.0 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал данс 10,504.0 мянга, бичиг хэргийн материал 1,276.9 мянга, бусад хангамжийн материал данс 1,075.3 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,552,998.2 мянган төгрөг болж 1,962,185.5 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.05.13-ны өдрийн 198 дугаар тогтоолоор 2,043,583.2 мянган төгрөгийн өртөг бүхий конторын барилга, 2022.12.14-ны өдрийн А-1/2429 дугаар тогтоолоор 41,140.9 мянган төгрөгийн өртөг бүхий компьютер тоног төхөөрөмжийг хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Мөн тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2022.12.28-ны өдрийн 480 дугаар тогтоолоор 125,237.9 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хуучин барилгыг Баянхонгор аймгийн Шүүхийн шинжилгээний албанд шилжүүлэхээр шийдвэрлэж, мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022.09.26-ны өдрийн А-1/1865 дугаар тогтоолоор 10 нэр төрлийн 17,300.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах шийдвэр гаргасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,388,286.1 мянган төгрөг болж 1,910,124.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,052,929.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,052,929.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 65,775.4 мянган төгрөгөөр бууруулж 987,154.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 987.154.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 968,952.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 968,952.4 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 11,361.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 3,501.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,066.2 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70205 Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	987,154,500.00	968,952,363.00	18,202,137.00	98.2%
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	909,860,300.00	891,752,929.00	18,107,371.00	98.0%
3	80219 Харуул, хамгаалалтын зардал	21,600,000.00	21,505,250.00	94,750.00	99.6%
4	80220 Холбооны суваг ашигласны хөлс	55,694,200.00	55,694,184.00	16.00	99.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1,500.0 мянга, Засаг даргын нөөц хөрөнгөөс 12,000.0 мянга нийт 13,500.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 13,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Татварын хэлтэс нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Татварын хэлтэс 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээ сарын 20-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,136,966.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,148.2 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,938.1 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2022 оны бичиг хэргийн зардлыг 2,447.2 мянга, дотоод албан томилолтыг 3,311.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,045.8 мянган төгрөг нийт 6,804.0 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

Харин Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-т заасны дагуу шалгахад тус байгууллага нь шинээр 2020 онд баригдсан барилгад үйл ажиллагаа явуулдаг ба тус байгууллагын ахлах түшмэлийн өрөөний

талбай 8м² байхаас 62.7 м² буюу 54.6м²-аар илүү, дэс түшмэлүүдийн өрөөний талбай нэг албан хаагчид 8м² байхаас нэг албан хаагчид 16.8м² буюу 8.8 м² илүү ногдож байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 1,038,081.1 мянган төгрөгийн 25 мэдээлэл, 6.4.8-д “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл”-д заасан 90,168.9 мянган төгрөгийн 25 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Доржханд гүйцэтгэж аудитаар 17,164.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2022.06.20-ний өдрийн 255 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0	0	0	0	
Албан шаардлага	0	0	0	0	
Зөвлөмж	2	17,164.9	2	17,164.9	100
Нийт дүн	2	17,164.9	2	17,164.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,118.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тус байгууллагын нягтлан бодогч нь 1118.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг аж ахуйн материал дансанд бүртгэсэн байна.

Аудитаар нийт 3,606.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 3,606.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

5.1.1 Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-т заасны дагуу шалгахад тус байгууллага нь шинээр 2020 онд баригдсан барилгад үйл ажиллагаа явуулдаг ба тус байгууллагын ахлах түшмэл /дарга/-ын өрөөний талбай 8м² байхаас 62.7 м² хоёр өрөө буюу 54.6м²-аар илүү, дэс түшмэлүүдийн өрөөний талбай нэг албан хаагчид 8м² байхаас нэг албан хаагчид 16.8м² буюу 8.8 м² илүү ногдож байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7.3-д заасан "Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, байрны ашиглалтыг сайжруулж ажиллах албан шаардлага хүргүүлж байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад Татварын ерөнхий газрын даргын тушаалаар Архив-бичиг хэргийн эрхлэгч-нярав гэсэн 1 орон тоог баталсан байхад Сүлжээний инженерт няравын ажлыг хавсруулан албан тушаалын 30 хувиар сар бүр цалинжуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасан "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын Ерөнхий газрын даргын 2022.05.18-ны өдрийн А/56 дугаар тушаалаар баталсан "Татварын ерөнхий газрын харьяа нэгж, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн орон тоог шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу орон тоог мөрдөж төсөвт тусгагдаагүй нэмэлт зардал гаргадаг байдлыг таслан зогсоох.

2. Хууль журмын хэрэгжилттэй холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд нийт 1118.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан ч өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд хийсэн урсгал засвартай холбоотой зардлыг гаргахдаа өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулан, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн	1	1,118.0			1	1,118.0	1	1,118.0		
Санхүүгийн тайланд бүртгээгүй										
Дүн	1	1,118.0			1	1,118.0	1	1,118.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тайлант хугацааны цалингийн зардлыг тулгахад Татварын ерөнхий газрын даргын тушаалаар Архив-бичиг хэргийн эрхлэгч-нярав гэсэн 1 орон тоог баталсан байхад Сүлжээний инженерт няравын ажлыг хавсруулан албан тушаалын 30 хувиар сар бүр цалинжуулсан байна.	1	2,488.6						1	2,488.6
Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд нийт 1118.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан ч өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргаагүй байна.	1	1,118.0						1	1,118.0
Нийт дүн	2	3,606.6						2	3,606.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчил									
Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-т заасны дагуу шалгахад тус байгууллага нь шинээр 2020 онд баригдсан барилгад үйл ажиллагаа явуулдаг ба тус байгууллагын ахлах түшмэлийн /дарга/	1	0			1	0			

Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

өрөөний талбай 8м2 байхаас 62.7 м2 2 өрөө буюу 54.6м2-аар илүү, дэс түшмэлүүдийн өрөөний талбай нэг албан хаагчид 8м2 байхаас нэг албан хаагчид 16.8м2 буюу 8.8 м2 илүү ногдож байна.								
Дүн	1	0			1	0		

-----oO-----